

8.7 Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн шугам сүлжээг хамгаалж бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

8.8 Ус хангамжийн төв шугамаас огтлогоог техникийн нөхцөл олгосон газраар /"Дархан-Ус суваг" ХК/ хийлгэнэ.

8.9 Хэрэглэгч нь батлагдсан зураг төслийн дагуу ус хангамж ариутгах татуургын сүлжээний угсралтын ажлыг "Дархан-Ус суваг" ХК-ийн техникийн ажилтаны хяналт зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.

9. Хэрэглэгч нь усан хангамж ариутгах татуургын системийн угсралтын ажлыг хийж дуусгасаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан шахалт угаалгыг хийж холбогдох акт баримтуудыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд
- Гүйцэтгэлийн зураг
- Хэсэгчлэн хүлээн авсан ажлын актууд
- Шугамын материалын сертификатын хуулбар
- Хэмжүүрийн гэрчилгээ
- Цэвэр усны шинжилгээ хийлгэсэн бичиг

10. Тоолуур хэмжих хэрэгсэл:

10.1 Айл өрхийн хэрэглээнд ф15мм-ийн хангагчаас зөвшөөрсөн LXSG-K, LXSG-R загварын хүйтэн, халуун усны ухаалаг тоолуурыг суурьлуулах. Зоорийн давхарт суурилуулах бол нэмэлтээр "indoor gateway" төхөөрөмжийг суурилуулах.

10.2 Тоолуурыг шугам хоолойд суурилуулахдаа хэвтээ байрлалд суурилуулах. Зураг төсөвт тоолуурын урт-165мм, өндөр-148мм, өргөн-98мм байхаар төлөвлөж өгөх.

10.3 Шинээр угсарч байгаа бүх тоноглолыг нийлүүлэхээс өмнө, техникийн өгөгдлийг хангагч байгууллагын Бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлж зөвшилцөхөөс гадна угсралт хийхийн өмнө ашиглагчаар туршилт, хэмжилт хийлгэж актаар баталгаажуулсан байа.

10.4 Боловсруулах үйлдвэрүүд бохир усны тоолуур тавиулна. Машин угаалгын газрууд, цайны газрууд нь тос баригч хийсэн байх шаардлагатай

10.5 Тухайн барилгын ус хангамжийн гадна сүлжээнд гал унтраах гидрант тавина.

10.6 Усны хэмжүүрийн зангилааг үзлэг хийхэд тохиромжтой ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгтэй +5 хэмээс дээш температуртай өрөөнд байрлуулна.

11. НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙРАНД АЙЛ ӨРХИЙН ЦЭВЭР УС БОЛОН ХЭРЭГЦЭЭНИЙ ХАЛУУН УСНЫ УХААЛАГ ТООЛУУР СУУРИЛУУЛАХ. ЯЛТСАН ХАЛААГЧИЙН ХҮЙТЭН УСЫГ ЕРӨНХИЙ ТООЛУУРТ ОРУУЛЖ ХОЛБОХ, ХАЛУУН УСНЫ ТООЛУУР ТАВИХ.

12. Барилгын ажил эхлэхээс өмнө цэвэр усны түр холболт хийлгэж тоолуур тавиулж гэрээ хийнэ.

13. Уг объектыг барих талаархи дээд байгууллагын тогтоол шийдвэрийн заалт: **Аймгийн Засаг даргын 2022 оны 09-р сарын 06-ны өдрийн А/240 тоот захирамж.**

14. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа 2 жил бөгөөд хэрэглэгч нь хугацаа дууссан үед шинээр материал бүрдүүлж техникийн нөхцөлийг сунгуулна.

15. Техникийн нөхцөлийг 2% үйлдэж холбогдох газруудад хүргүүлнэ.

16. Техникийн нөхцөлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

17. Техникийн нөхцөлийн үндсэн төлбөрийг огтлогоо заах шугамын диаметр болон барилга объектын тооноос хамааруулан авна.

18. 04-р сарын 01-нээс 10-р сарын 15-ний хооронд огтолгоо авч холболт хийсэн байх шаардлагатай.

19. **Техникийн нөхцөлийг дур мэдэн хангагчид мэдэгдэлгүй өөрчилсөн тохиолдолд техникийн нөхцөлийн үнийг 5 дахин өсгөж торгууль ноогдуулна.**

20. **5-н давхараас дээшхи барилгад өргөлтийн насос суурилуулах.**


21. Бохир усны шугам холбох боломжгүй нөхцөлд "Дархан-Ус суваг"-тай гэрээ хийж, зориулалтын авто машинаар бохир усыг соруулж зайлуулна.

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОСОН:

"ДАРХАН УС СУВАГ" ХК-ИЙН:

ДЗ. ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:

ГОРИМЫН ИНЖЕНЕР:



Т.БУЯНДЭЛГЭР

Ө.СОЛОНГО